





TSX:ERD | MSE:ERDN

ERDENE
RESOURCE DEVELOPMENT

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРП.

Давхар бүртгэлийн тухай

2019 оны 1 сарын 25

-  www.erdene.com
-  ErdeneRes
-  ErdeneResource
-  Erdene Resource Development Corp.
-  Erdene Resource Development

Уг танилцуулга нь урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь дараах үгсээр тодорхойлогдоно. Үүнд: (урьдчилан сэрэмжлүүлэх), (төлөвлөх), (зорилго), (эрэх хайх), (итгэх), (төсөвлөх), (үнэлэх), (тооцоолох), (стратегий), (ирээдүй), (боломжит байдал), (таамаглах), (байх) зэрэг ирээдүй цагт хамааралтай үгсээр илэрхийлэгдэнэ.

Уг урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн Компанийн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлан гарсан одоогийн үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Зарим нэг тодорхойгүй болон урьдчилсан харах боломжгүй нөхцөл байдал нь компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх магадлалтай. Эдгээр хүчин зүйлд материаллаг байдлаас хамааран зах зээлийн үнэ, хайгуул болон олборлолтын үр дүн, санхүүжилтийн нөхцөл байдал болон ерөнхий эдийн засаг, зах зээл, бизнесийн нөхцөл байдлууд орно. Компанийн урьдчилсан таамаглал нь энэхүү мэдэгдлээр илэрхийлэгдэж буй хөрөнгө оруулагчдад анхааруулах мэдэгдэл юм.

Дээрхи урьдчилсан таамаглал дахь мэдээллээс гадна энэхүү танилцуулгад: хайгуулын судалгааны үр дүн, нөөцийн тайлангийн үр дүн, шинэ эрдсийн нөөцийг тодорхойлох, баялгийг нөөцөд шилжүүлэх, нэмэлт хөрөнгө оруулалт татах, ирээдүйн санхүүжилт, хөрөнгийн зардал болон зардлууд, үүнд төсөвлөсөн зардлууд, Компанийн байгаль орчин, аюулгүй ажиллагаа болон бусад Хөндийн төслийн хөгжүүлэлттэй холбоотой тусгай зөвшөөрлийн нөхцлүүд, үнэт металлын үнийн төсөөлөл, тусгай зөвшөөрлийн хүсэлт, авах тухай мэдээллийг агуулсан.

Урьдчилсан таамаглал нь төсөөлөл болон тооцоололд тулгуурласан бөгөөд дээрхи мэдээлэл, мэдэгдлүүд нь үндэслэлтэй гэж үзэж байгаа боловч бизнес, эдийн засаг болон өрсөлдөх чадвартай холбоотой тодорхойгүй, тооцоологдоогүй байдлыг үүсгэх боломжтой. Тодорхой болон тодорхойгүй байдал, үр дүнд нь энэхүү урьдчилсан таамаглалд тодорхойлсоноос гадна өөрчлөгдөн, материаллаг өөрчлөлт орох боломжтой. Энэхүү хүчин зүйлд алт болон бусад эрдсийн бүтээгдэхүүний үнэ, Компани ирээдүйд хөрөнгө босгон бизнесийг үргэлжлүүлэх чадвар, засгийн газар болон захиргааны байгууллагын хууль тогтоомжийн өөрчлөлт, татварын орчин, Монгол улс дахь эдийн засаг, усл төрийн нөхцөл байдал, Компанийн нөөцийн тодорхойлох чадвар, эрдсийн агуулга, анхан шатны эдийн засгийн тооцоолол, Хөндий таслийн геологи, судлын структур, ашиглалт болон хөгжүүлэлттэй холбоотой эрсдлүүд, мөн хайгуул, олборлолттой холбоотой эрсдлүүд үүнд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авах боломж, хангамж болон техник тоног төхөөрөмжийг хангах чадвар зэрэг багтана. Дээрхи тодорхойгүй, тооцоологдоогүй нөхцөл байдал, хүчин зүйлс нь Компанийн үйл ажиллагаа, материаллаг байдалд нөлөөлөх, энэхүү болон бусад урьдчилсан таамаглалд тусгагдаагүй байх магадлалтай.

Уншигчдад анхааруулахад энэхүү урьдчилсан таамаглал дахь мэдээлэл нь Компанийн ирээдүйн үйл ажиллагааны баталгаа болохгүй. Эдгээр мэдэгдэл, мэдээлэл нь ирээдүйн үйл ажиллагаанаас шалтгаалан, тодорхойгүй байдал болон эрсдлүүдээс шалтгаалан өөрчлөгдөх магадлалтай. Дээр дурдсан эрсдлүүдэд алтны үнийн хэлбэлзэл, хайгуулын боломж, нөөцийн тодорхойгүй байдал, эрдсийн агуулга болон металл авалтын тооцоолол, хайгуул болон хөгжүүлэлтийн төлөвлөгөө саатах, санхүүжилт саатах, шаардлагатай тусгай зөвшөөрөл саатах, ордуудын эдийн засгийн тооцоолол буурах, хайгуул болон хөгжүүлэлтийн зардал, уул уурхайн салбарын өрсөлдөх чадвар, голлох удирдах албан тушаалтан, ажилтантай холбоотой эрсдэл, маргаан, засгийн газар, хууль эрхзүйн байдалтай холбоотой өөрчлөлтүүдээс үүсэх зардлын өсөлт, байгаль орчны зардал, эрсдэл, гэмтэл болон хөдөлмөртэй холбоотой маргаан гарах зэрэг багтах боловч үүгээр дуусгавар болохгүй. Дээрх эрсдлүүд гарч, компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх тохиолдолд энэхүү урьдчилсан таамаглал, мэдэгдэлд тусгагдсанаас өөрөөр нөлөөлөх, материаллаг өөрчлөлт гарах боломжтой. Компанийн жилийн тайлан дахь эрсдлийн хүчин зүйлтэй www.erdene.com-ооc 2018 оны 3 сарын 26-нд тайлагдсанаар, эсвэл www.sedar.com-д тайлагдсанаар танилцаж болно. Компани хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд энэхүү ирээдүйд энэхүү урьдчилсан таамаглалтай холбоотой мэдээ мэдээллийг шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Бүх валютын нэгж нь өөрөөр заагаагүй тохиолдолд Канад доллараар тайлагнагдсан.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корп. нь :

2000.07.14 – Канад улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан,

2004.03.05 - Торонтогийн Хөрөнгийн Бирж - Венчур бүртгүүлсэн

2005.12.14 – Торонтогийн Хөрөнгийн Биржид арилжаалагдаж эхэлсэн (TSX : ERD)

2018.06.14 – Монголын Хөрөнгийн Биржид давхар бүртгүүлсэн (MSE : ERDN)

Үйл ажиллагааны цар хүрээ:

- Ашигт малтмалын хайгуул, олборлолт
- Төсөл хөгжүүлэлт

Компанийн бүтэц, засаглал

Компани ба охин компаниудын бүтэц



Компанийн зохион байгуулалтын бүтэц



Компанийн хөрөнгийн бүтэц

Энгийн хувьцаа: **146,400,586** ширхэг энгийн хувьцаа

Опцион: \$0.39 долларын дундаж үнэ бүхий **9,316,250** опцион

DSU: \$0.86 долларын жигнэсэн дундаж үнэ бүхий **3,410,186** DSU

Нөхөн төлөх опцион: 2019.02.22 хүртэл хэрэгжүүлэх боломжтой \$1.20 долларын үнэлгээ бүхий **1,075,324** нөхөн төлөх опционтой

Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо хэмжээ	Хувь
Teck Resources Ltd	13,222,904	9.03%
ТУЗ-ийн гишүүд, захирлууд	13,644,752	9.32%
Нийтэд арилжаалагдаж буй	119,532,930	81.65%
Нийт	146,400,586	100%

ТУЗ-ийн шийдвэр болон хамтран ажилласан

2017.12 - Давхар бүртгэл хийх компанийн дотоод шийдвэр, үнэт цаасны танилцуулгын бэлтгэл эхлэх

2017.12-2018.01 – Хамтран ажиллах байгууллагуудтай гэрээ

Хийх

Андеррайтер (Тэргүүлэх андеррайтер/ Хамтрагч андеррайтер)

- Санхүүгийн зөвлөх
- Хуулийн зөвлөх (Хуулийн дүгнэлт гаргах дотоод зөвлөх/ гадаад хуулийн зөвлөх)
- Аудитор
- Техникийн зөвлөх (Хайгуул, олборлолт уул уурхайн компанийн хувьд)

2018.02.12/2018.05.16 – ТУЗ-ийн шийдвэр

- МХБ-д бүртгүүлэх хувьцааны тоо, төрөл (4,000,000 энгийн хувьцаа)
- Хувьцааны үнийг тогтоох арга (ТХБ-ийн 10 хоногийн жигнэсэн дундаж ханш “10 day VWAP”)
- 10% хөнгөлөлттэй ханшаар тогтоосон
- Эрх бүхий албан тушаалтан, итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох (Охин компани)
- Санал болгож буй нэгж хувьцааны үнэ (₮620/ \$0.34)

Шийдвэрлэлтийн агент (“Transfer agent”) - д хувьцаа гаргах, бүртгэх зааварчилгаа өгөх

Бэлтгэл ажлууд 2018.01-2018.03

Үнэт цаасны танилцуулга

- Англи, Монгол хувилбар
- Анхдагч бүртгэл хийлгэсэн (“IPO”) үнэт цаасны товч танилцуулга, орчуулга
- 2 улсын хууль эрхзүйн зөрүүтэй байдал, эрсдэл

Хуулийн дүгнэлт

- 2 улсын хууль эрхзүйн зөрүүтэй байдал, эрсдэл (Монгол/ Канадын хуульчид хамтран боловсруулсан)

Техникийн дүгнэлт

- МХБ-ийн үнэт цаасны бүртгэлийн журмын 4.8.11 дагуу Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн баталгаажуулсан техникийн тайлан, санал дүгнэлт

Өргөдөл, бүртгэл

2018.03.12 - СЗХ, МХБ-д давхар бүртгүүлэх хүсэлтийг зэрэг гаргасан

- Бүртгэлийн журмуудад заасан бичиг баримтуудыг хавсаргасан Үнэт цаасны танилцуулгыг өргөдлүүдийн хамт хүргүүлсэн.

2018.04.03/ 04.11 - МХБ-д нэмэлт мэдээлэл, тайлбар хүргүүлсэн.

- Санхүү байдал, аудитын тайлангийн талаар нэмэлт тайлбар хүргүүлсэн.
- Компанийн үйл ажиллагаа эрхэлдэг 2 сумын иргэдэд хувьцаа эзэмшүүлэх тухай нэмэлт тайлбар хүргүүлсэн

2018.04.23 СЗХ-д нэмэлт мэдээлэл, тайлбар хүргүүлсэн

- Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тухай нэмэлт мэдээлэл
- ТХБ-д давхар бүртгэл хийж буйг мэдэгдсэн мэдэгдэл
- 5%-иас дээш хувьцаа эзэмшигчийн тухай мэдээлэл
- Бүртгэлийн дараах үйл явцын тухай тодруулга

2018.04.04 МХБ-ийн тушаал гарсан.

2018.05.23 СЗХ-ны тогтоол гарсан.

Үнэт цаас хадгалах тухай (“ҮЦТХТ”)

Бүрдүүлэх материал (2018.06.05-нд ҮЦХТХ-д хүсэлт гаргасан)

- СЗХ-ны тогтоол
- МХБ-д бүртгэх тухай мэдэгдэл
- Хадгаламжийн маягт
- Хадгаламжийн гэрээ
- ААН-ийн гэрчилгээний хуулбар, нотариатаар баталгаажуулсан
- ХЭХ-ын хувьцаа гаргах тогтоол (Канадын ААН-ийн хувьд ТУЗ нь тогтоодог)
- Албан тоот, бүртгүүлэх хүсэлт (ISIN дугаар авах)
- Андеррайтерийн данс
- Төлбөр төлсөн баримт

Бүртгэл, дугаар олгох талаар

- ISIN дугаар авах
- Үнэт цаасны анхдагч бүртгэгч, агенттай хамтран ажиллах
- Corporate action тухай


Мэдээлэл, цагийн зөрүү, үнийн хэлбэлзэл

- Компанийн мэдээлэл олон нийтэд хэрхэн хүрэх тухай
- Цагийн зөрүүтэй байдал
- Ханшийн зөрүү
- Тогтмол биелүүлэх үүргүүд


Бусад үнэт цаасны бүртгэлээс ялгаатай байдал

- Санал болгосон 4,000,000 хувьцаанаас 150,000-ийг Компани үйл ажиллагаа эрхэлж буй 2 сумын иргэдэд нэр заан эзэмшүүлсэн
- МХБ-д олон нийтэд санал болгосон 4,000,000 хувьцааг бүртгэсэн,




 www.erdene.com

 ErdeneRes

 ErdeneResource

 Erdene Resource Development Corp.

 Erdene Resource Development